

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ  
3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт чиглэл хүргүүлж Улсын Их Хурлын сонгуулийн хэсэг байгуулах, Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх асуудлыг хуулийн хугацаанд нь зохион байгууллаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад оруулах саналыг сумдаас авч 14 заалт бүхий саналыг Улсын Их Хурлын Тамгын Газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолд заасны дагуу Засгийн газрын гишүүний аймгийн Засаг даргатай 2019 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлт, 2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээний аймгийн ЗДТГ-ын 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг журмын дагуу гаргаж хугацаанд нь ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т хүргүүллээ.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий аймгийн “Шуурхай штаб”-ыг Засаг даргын тамгын газарт ажиллуулж сум орон нутгийн мэдээллийг нэгтгэн улсын Онцгой комисс, хойд бүсийн төв, бусад холбогдох албан тушаалтнуудыг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

Тусгаарлах байрыг бэлтгэн 50 хүний өрөөг нэг удаагийн ахуйн хэрэглэлээр ханган тохижуулаад байна.

Монгол Улсад коронавируст халдвар /covid-2019/-ын анхны батлагдсан тохиолдол Франц улсаас зөөвөрлөгдөн орж ирсний улмаас Улсын Онцгой комиссоос зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комисс 3-р сарын 10-ны өдөр хуралдаж халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, сум, багаас гарах, орох хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07:00 цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 07:00 цаг хүртэл хугацаанд зогсоох шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд зориулан 3-р сарын 30-ны өдрийн байдлаар аймгийн Онцгой комисст нийт 39 иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас 39.9 сая төгрөгийн хандив цуглараад байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/84 дүгээр захирамжаар эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг шинэ коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийсэн.

Архангай аймагт шинэ коронавирүсийн халдвар орж ирсэн үед тархах эрсдэлийн үнэлгээг Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг дээрх байгууллагын дарга

мэргэжилтнүүд хамтран хийхэд өндөр эрсдэлтэй гарсан тухайн дүн мэдээг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулан ажилласан.

Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/134 дүгээр захирамжаар 2020 оны 03-р сарын 11-ний өдрөөс 16-ны өдрийг дуустал, 3 дугаар сарын 16-ны өдрийн а/150 дугаар захирамжаар 03 дугаар сарын 17-ны өдрөөс 31-ний өдрийг дуустал хугацаанд аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг тус тус хориглож, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажилласан.

Мөн сүм хийд, баар, караоке, кафе, тоглоомын газрууд 03 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаанд ажиллахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Аймгийн Онцгой комисс 3-р сарын 24-ний өдөр хуралдаж Улсын Онцгой комиссоос гаргасан хандив зарцуулах журмын дагуу тусгаарлах байранд шаардлагатай материал, халдвар хамгааллын хувцас хэрэглэл болон хяналтын пост, штабт ажиллах албан хаагчдын хоол цай, шатахуун, бичиг хэрэг, постны түлээ түлш, нийтийн эзэмшлийн зам талбай, хяналтын постонд ашиглах ариутгалын бодис, дархлаа дэмжих эм бэлдмэл, богино долгионы станц гэх зэрэг нийт 32 нэр төрлийн бүтээгдэхүүнийг нийт 34,4 сая төгрөгийн зардлаар авах, хандивын мөнгийг зарцуулах тухай, шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэл хийх тухай, үхсэн мал, амьтны сэг зэмээс үүдэн хүн, малын халдварт өвчин тархах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор, сэг зэм устгах аймгийн Засаг даргын А/180, А/181, А/182 дугаар захирамжууд болон “Орчны цэвэрлэгээ, сэг зэм устгах, халдваргүйтгэх шуурхай ажил зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар албан даалгаврыг гаргасан байна.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах зорилгоор аймаг, сумын хэмжээнд ахуйн хог хаягдал цэвэрлэх, халдваргүйтгэл хийх ажлыг 03-р сарын 25-наас 4 дүгээр сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулна.

Улсын Онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах боломжоор хангах, цалинтай чөлөө олгох арга хэмжээний хүрээнд уг шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга 0-12 насны хүүхэдтэй ажилтнуудад цалинтай чөлөө олгохыг бүх сум, агентлагийн дарга нарт чиглэл болголоо.

Аймгийн нөөцөөс сумдад үнэгүй олгогдож буй тэжээлийг хүлээлгэн өгөх, хаваржилтын нөхцөл байдалтай танилцах, коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх сумдын шуурхай штабын үйл ажиллагаатай танилцаж, заавар зөвлөгөө өгөх зорилгоор 5 ажлын хэсэг томилогдон 19 суманд ажиллаж сум тус бүрт 4тн тэжээлийг хүлээлгэн өглөө.

Өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан улсын нөөцөөс Архангай аймгийн 19 суманд 145 тн малын тэжээлийг 50 хувь хямдарсан үнээр, 120 тн өвсийг үнэгүй, аймгийн нөөцөөс сум бүрт 4 тн тэжээлийг үнэгүй олгосныг аймгийн удирдлагууд, холбогдох албаны хүмүүс сум бүрт шуурхай хүргэсэн байна.

Аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасангаар ахлуулсан ажлын хэсэг хаваржилтын нөхцөл байдал, коронавирусний халдвараас урьдчилан сэргийлэх шуурхай штабын үйл ажиллагаатай танилцан, заавар зөвлөгөө өгөх зорилгоор баруун таван суманд ажиллах Тариат сумын эмнэлгийн өргөтгөлийг 2021 оны улсын төсөвт санал оруулж, тусгаж өгөх, рентгэн аппаратыг ажиллуулах гол аппарат болох дижитал хувиргагч авахад шаардагдах 36 сая төгрөгийн зардал, Цахир суманд Галын машиныг оруулж ирэх гаалийн зардалд 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр аймгийн Засаг даргын зүгээс шийдвэрлэсэн байна.



- Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 2
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 3
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 7
- Нас баралтын бүртгэл - 47
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 69
- Дахин олгосон - 59
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 152 бүртгэл хийгдсэн байна.

**Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:**

2020 îíû 3 дугаар ñàðûí 25-ны áàéäëààð íèéð èðäýí ðóóëëéí ýðäýýäýýñ 504 ìýäççëäëéé ðçëýýí àâ÷ äàðààð áçððäýëëééé ðëééæ äçëóýðäýëýý.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 13
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 10
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 7
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 165
- Арилжааны гэрээ – 0
- Худалдах худалдан авах гэрээ – 20
- Бэлэглэлийн гэрээ – 3
- Барьцааны эрхийн бүртгэл – 121
- Өв залгамжлал – 5
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 4
- Лавлагаа – 1
- Бусад эрхийн бүртгэл – 5

Хóóëü ðýíàèððíí áàéäóóëëäáàäá íèéð 47 äàâëäáàäá äàðäàí ðçðäççëñýí áàéíà. дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 1.372.590 тэмдэгтийн хураамжид 67194 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 2.681.000 төгрөг төвлөрүүлсэн байна.

**Хуулийн этгээдийн чиглэлээр:**

- Шинээр бүртгүүлсэн – 6
- Өөрчлөлт – 6
- Тамганы хяналтын дугаар олгосон – 8 бүртгэл хийсэн.

3-р сард тус аймагт 9 удаагийн аюулт үзэгдэл тохиолдсон байна. Үүнд: объектын гал түймэр 6, мал амьтны халдварт өвчин 3

Улсын онцгой комиссын шийдвэрээр 2 удаа буюу 02-р сарын 23-наас 03 дугаар сарын 03-ны өдөр, 3 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд аймаг, сум, хотоос гарах, хот руу орох, хот хоорондын тээвэр, хувийн автомашины хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан аймгийн 19 сумын хэмжээнд нийт 69 хяналтын постод 300 гаруй төрийн байгууллагын албан хаагчид 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллалаа.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг тендерт шалгарсан “Мэргэн насан” ХХК, “Дондог боржигон” ХХК, “Цогч ариутгал” ХХК-иуд 02 дугаар сарын 13-ны өдрөөс 03 дугаар сарын 13-ныг хүртэл хугацаанд 430 төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 2675 объект, барилга байгууламжийн 178984.4м<sup>2</sup> талбайд ариутгал, халваргүйжүүлэг хийгээд байна.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалт явуулах удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1, 2, 3, 4, 5, 7 гэсэн 6 багийн гэр хорооллын айл өрхүүдэд Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гал түймрийн улсын хяналтын

дүрэм, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм бусад стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд 6 ажлын хэсэг Эрдэнэбулган сумын 6 багийн нийт 1915 айл өрхөд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 2679 зөрчил илрүүлж 658 зөрчлийг газар дээр нь арилгуулан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 9, мэдэгдэл 6-ийг тус тус бичиж холбогдох иргэдэд хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.

“Иргэний хамгаалалтын өдөр”-өөр “Коронавирусээс урьдчилан сэргийлэх”, “Анхны тусламж үзүүлэх” сэдэвт нийт 13 удаагийн цахим зайн хичээлийг 7023 хүн үзэж, хандалт авсан байна. Мөн орон нутгийн телевизээр өдөрт 3 удаагийн давтамжтайгаар 21 удаа нэвтрүүлж иргэдэд хүргэлээ.

2020 оны 3 дугаар сард аймгийн хэмжээнд 127 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг-22, хулгайлах гэмт хэрэг-64, малын хулгайн гэмт хэрэг -43, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг-6, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 15 байна.

Нийт 5676 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 5463 иргэнд 181 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 550.2 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 38.2, нийт гэмт хэргийн илрүүлэлт 32.5 хувьтай байна

Шүүхийн шинжилгээний алба 3-р сард криминалистикийн шинжилгээ 9, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 29, шүүх эмнэлгийн шинжилгээ 29, тусгай шинжилгээ 7-г тус тус хийсэн байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2060849.8 төгрөгийн мөнгөн дүн бүхий 389 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 27.6, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 15 байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас “COVID 19” халдварын дэгдэлтийн үеийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Эрүүл мэндийн 35 байгууллагад дэмжлэгт хяналт шалгалт хийж, биелэлтэнд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд ЭМБ-д бэлэн байдлыг 70-90%-тай хангасан байна.

Эрдэнэбулган сумын хүн амын ундны усны эх үүсвэр болох 25 цэгээс дээж авч МХГ-ын лабораторит шинжилгээнд хамруулсан.

Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 76 газарт өргөн хэрэглээний хүнсний бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үнийн өөрчлөлтөнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж. хугацаа нь дууссан, шошгын зөрчилтэй 280 нэрийн 107 ширхэг, 2719 ширхэг 6.3 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн 22 актаар хураан авч, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлд шилжүүлж, зөрчил гаргасан 5 иргэнд Зөрчлийн тухай хуулиар шийтгэл ногдууллаа.

Баар, караоке, кафе, бүх төрлийн сүм хийдийн үйл ажиллагааг түр зогсоон, хүнсний дэлгүүр, зоогийн газрын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн үйлчлэх цагийн хуваарийг 10:00-17:00 цаг хүртэл тогтоон цагийн хуваарьт хязгаарлалт хийсэн, “Шинэ коронавирусын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 02-р сарын 13-ны өдрийн А/58 дугаар захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж 3-р сарын 07-ны өдрөөс 11-ний өдрүүдэд 19 цэгт хяналт шалгалт хийхэд илэрсэн зөрчилгүй байв.

Аймгийн Засаг даргын “Шинэ короновирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” А/134 дугаар захирамжаар 2020 оны 3 дугаар сарын 11–ний өдрөөс 16–ны өдрийг дуустал хугацаанд аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх, мөн Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, ресторан, нийтийн хоолны газруудын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасантай холбогдуулан 107 хүнсний дэлгүүрийн согтууруулах ундааг битүүмжилж, 14 цайны газар, 18 зоогийн газар, 2 баар, 6 караоке, 14 зочид буудлын үйл ажиллагааг зогсоон, нийт 155 газрын цагийн хязгаарлалтанд хяналт тавин ажиллалаа.

2020 оны 03 сарын 16-ны өдөр хийсэн шалгалтаар захирамж зөрчин ажиллаж байсан 2 зоогийн газар, 3 зочид буудлын үйл ажиллагааг зогсоосон.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсролын чиглэлээр**

Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосонтой холбогдуулан Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн теле хичээлүүдийг телевизийн суваг болон бусад онлайн сувгийг ашиглан зохион байгуулж байгаа арга хэмжээг анхан шатны нэгжид хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхэд нэг бүртэй холбоотой ажиллах, теле хичээлд хамрагдаж буй явц байдалд дүн шинжилгээ хийх, бусад онлайн сувгийг ашиглан хүүхэд, эцэг эхчүүдтэй байнгын харилцаа холбоотой ажиллахыг ЕБС, СӨБ-ын удирдлага, багш нарт үүрэг болгон ажиллаж байна.

ЭЕШ-ийн бүртгэлийн зааварчилгаа, хичээлд хамрагдах, шалгалтад бэлтгэх чиглэлийг ЕБС-иудад цаг алдалгүй цахимаар хүргүүлэн ажиллаж байна.

## **Соёл урлагийн чиглэлээр**

Номын сангийн MonKoha программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд ХНО-ы 802 нэрийн 1643 номыг шивж, бар код нааж, ном алдагдахаас сэргийлж, 5000 номонд соронзон ялтас наан, урагдаж гэмтсэн 685 номыг сэлбэн засч байрлууллаа.

Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан Номын сангийн уншлагын танхим, зөөврийн болон гэрээр ном олгох үйлчилгээ, Хөгжимт драмын театрын тоглолт, үзвэр үйчилгээ, Музейн үзвэрийг түр зогсоосон байна.

## **Эрүүл мэндийн чиглэлээр**

Аймгийн Эрүүл мэндийн албаны штаб 24 цагаар бэлэн байдалд ажиллаж, 3 удаа хуралдаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, шаардлагатай нөөцийн судалгаа гаргаж, аймгийн Онцгой комисст танилцуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж чадавхжуулах, иргэдэд хүргэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр шаардлагатай асуудлыг тухай бүр хэлэлцэн, шийдвэрлэж байна. Мөн эрүүл мэндийн байгууллагуудаас өдөр бүр бэлэн байдалд ажилласан тайланг авч, зөвлөмжөөр хангаж байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага, иргэдийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжийг шинэчлэн боловсруулж, худалдаа, үйлчилгээний байгууллага, төрийн байгууллага, хувийн хэвшлийн нийт 85 байгууллагад хүргүүлсэн.

Шинэ коронавирусын халдварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор иргэдэд санамж мэдээллийг ЭМГ-ын албан сайт, цахим хуудсуудаар өдөр бүр шинэчлэн хүргүүлж байна. 3 сард 26 төрлийн материалыг цахим сүлжээнд оруулсныг 42969 хүн үзэж, 16819 хүн бусадтай хуваалцсан.

Аймгийн төвд хувиараа такси үйлчилгээ эрхэлдэг 15 машинд коронавирусын халдвараас сэргийлэх зөвлөмжийг наасан.

Хот хоорондын зорчигч тээврийн автобусаар ирж байгаа иргэдийн биеийн байдалд тандалт хийх үйл ажиллагаанд өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн эмнэлэг, сургуулийн эмч нарыг дайчлан ажиллуулж, 3 сард нийт 1386 хүний халууныг хэмжиж, эрүүл мэндэд тандалт хийлээ.

Аймаг, сум, хот хоорондын хөдөлгөөний хязгаарлалт хийсэн хугацаанд аймгийн нийт 58 хяналтын постонд давхардсан тоогоор 2583 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж, 13247 иргэний халууныг хэмжиж, эрүүл мэндэд тандалт хийсэн.

“Сүрьеэтэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулах, хүн бүрийн хүчин чармайлт чухал” сэдвийн дор “Сүрьеэ өвчинтэй тэмцэх Дэлхийн өдөр”-ийн хүрээнд ДЭМБ, НЭМҮТ-ээс ирүүлсэн 12 төрлийн зурагт хуудас, 6 төрлийн инфографик, 10 төрлийн видео шторкийг Эрүүл мэндийн газрын цахим сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэж байна.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр**

2020 оны 3 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 975 иргэн бүртгэлтэй байгаагаас 498 эмэгтэй, Шинэ ажлын байр 97 үүнээс байнгын ажлын байр 65, улирлын ажлын байр 3, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 83, зуучлал 72 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 92 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 8, бага-23, суурь-145, бүрэн дунд-594, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 23, тусгай мэргэжлийн дунд-19, Дипломын бакалаврын-163 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 18 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд 41 иргэн хамрагдаж нийт 358 000 000 төгрөгийн зээл олголоо. Үүний үр дүнд 110 ажлын байр бий болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг 2020 оны 02-р сарын 17–ны өдрөөс 03-р сарын 30-ны өдөр хүртэл зарлалаа.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 3 дугаар сарын байдлаар нийт 3813.1 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 123 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14.1 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 9.8 тэрбум төгрөг зарцууллаа.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр**

Аймгийн Засаг даргын 2020 оны а/91 дүгээр захирамжаар 19 суманд хүүхэд гэр бүлийн эрсдлийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ хийх, зураглал гаргах чиглэл өгч ажилласан ба өнөөдрийн байдлаар 19 сумын 12010 өрх буюу нийт өрхийн 43 хувийг хамруулаад байна.

Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой дэмжлэг үзүүлэх шаардлагатай 52 хүүхдэд 17,100 төгрөгийн, эрсдэлт нөхцөлд амьдарч буй 123 өрхөд тус бүр нь 20.000 төгрөгийн өртөг бүхий эрүүл мэндийн багц, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж 3460,000 төгрөгийг зарцуулсан байна.

Түр хамгаалах байранд амьдарч байгаад гэр бүлдээ эргэн нэтгэгдсэн 8 хүүхдийн нөхцөл байдалтай танилцаж 98900 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Хүүхэд хамгааллын хичээл цуврал-1,2, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах зөвлөмж-1, ариутгал халдваргүйжүүлэлтийн болон халдвараас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг харгалзах хүнгүй гэрт үлдээх, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх гэсэн 19 төрлийн зөвлөмж, уриалга, санамж, сэрэмжлүүлгийг боловсруулан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30000 орчим иргэнд хүргэж, мөн 575 ширхэг гарын авлагыг иргэдэд тараасан байна.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй**

2019 оны эцэст 17.3 мянган малчин, мал бүхий өрхөд 6167.0 мянган толгой мал үүнээс тэмээ 1.4 мянга, адуу 425.9 мянга, үхэр 710.1 мянга, хонь 3321.3 мянга, ямаа 1708.4 мянган толгой тоологдсон байна. Малын тоо толгойг өмнөх онтой харьцуулахад 11.2 хувь буюу 675.6 мянган толгойгоор өссөн үзүүлэлт гарсан

Аймгийн хэмжээнд энэ онд 2652.1 мянган толгой эх мал төллөхөөс 144283 толгой эх мал төллөж 123092 толгой төлийг 85.3 хувьтай бойжуулж байна.

Аймгийн хэмжээнд нийт мал сүргийн 1.5 хувь буюу 91.4 мянган толгой мал зүй бусаар хорогдсон. Үүнээс Хайрхан, Цэцэрлэг, Өлзийт, Жаргалант, Өндөр-Улаан, Эрдэнэмандал сумдууд хорогдлын дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд зудын эрсдэлийн түвшинг тодорхойлоход 10 сум зудын эрсдэлийн түвшин дунд буюу шар, 9 сум их буюу улаан өнгөтэй зудын эрсдэлтэй байна. Үүнд: Өгийнуур, Хангай, Хашаат, Төвширүүлэх, Өлзийт, Батцэнгэл, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, сумууд зудархуу үнэлэгдсэн учир зудын эрсдэлийг бууруулах нийт 11 зөвлөмж боловсруулан тухайн сумдад хүргүүлэн ажиллалаа.

Шинэ коронавирусийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай Аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаварт тусгагдсан хүн амыг хүнсний хомсдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, нөөцийн судалгааг 7 хоног бүр авч нэгтгэн холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

03 сарын 24-ний байдлаар мах 153.8 тн буюу 12 хоног, гурил 202.4 тн буюу 27 хоног, гоймон 24.5 тн буюу 2 хоног, будаа 73.4 тн буюу 19 хоног, сахар 43.3 тн буюу 17 хоног, ургамлын тос 13.8 тн буюу 8 хоног, давс 22.4 тн буюу 56 хоног, ундны ус 28.4 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 4.4 тн буюу 9 хоног, төмс 43.7 тн буюу 4 хоног, хүнсний ногоо 23.8 тн буюу 2 хоног, өндөг 1.15 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малчдыг хоршоо, бүлэг, нөхөрлөлийн зохион байгуулалтаар ажиллах, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэх, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, малчдын санал, хүсэлтийг авч мэдээллийн сан бүрдүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх бодлогыг сайжруулах зорилгоор "Малчин лавлах 109" мэдээллийг самбарыг сумдын Хөдөө аж ахуйн тасагт хүргүүлэн холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албанд хашаажуулалт, ойн зурвас байгуулсан тухай судалгаа хүргүүлэв. Архангай аймгийн 19 сумын хэмжээнд 11311,1 га талбай бүхий 778,3 км газрыг хашаажуулахад улсын төсвөөс 151 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 69 сая төгрөг, хувиасаа 1457,536 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн “нэгдсэн хяналт шалгалт хийх төлөвлөгөө”, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргын 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн “Малын мах бэлтгэн, худалдаалж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хууль, журамд заасны дагуу явагдаж байгаа эсэхийг шалгах удирдамж”-ийн дагуу Эрдэнэбулган, Ихтамир суманд байрлах малын мах бэлтгэн, худалдаалах үйл ажиллагаа явуулж буй нийт 10 иргэд, 5 аж



ахуйн нэгжүүдийн малын мах хадгалж буй зоориудын үйл ажиллагаатай танилцаж, мах хадгалж буй хөргөлтийн агуулах зооринд үзлэг хийлээ. Үүнд:

“Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар батлах тухай” Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/51 тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахад нэгдсэн хяналт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгжүүдэд мал, амьтны эрүүл мэнд, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийг тодорхойлох, баталгаажуулалтын гарал үүслийн гэрчилгээгүй болох зөрчил илэрснийг ариулгуулахаар шийдвэрлэлээ.

Хайрхан, Өлзийт, Цэцэрлэг, Төвшрүүлэх, Батцэнгэл, Цэнхэр, Хашаат, Өгийнуур, Өндөр-Улаан сумдаас Мал эмнэлгийн Лабораторийн шинжилгээнд 90 эмгэгт дээж ирүүлснийг холбогдох стандарт арга зүйн дагуу шинжилгээ хийж гүйцэтгэхэд Галзуу-8, Цусан халдварт-2, ДХХ-8 бүгд 18 халдварт өвчин тодорхойлогдож тэмцэх зааврын дагуу арга хэмжээг авч ажиллаж байна. 3 дугаар сарын 19-ний байдлаар лабораторийн туршлагын амьтан 2-г шинжилгээнд хэрэглэж оношийг баталгаажууллаа.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр**

Олон улсын Ойн өдрийг угтан шилмүүст модыг мөчрөөр үржүүлэх, хот суурин газрын цэцэрлэгжүүлэлтэд шаардлагатай тарьц, суулгацны нөөцийг бүрдүүлэх зорилгоор улиас, бургасны 3000 шахам мөчир бэлтгэлээ.

Ой, хээрийн түймрийн аюултай үе эхэлсэнтэй холбогдуулан ойд аливаа үйл ажиллагаа явуулж буй иргэн, ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх хяналт шалгалтын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллалаа. Энэ ажлын хүрээнд давхардсан тоогоор 20 гаруй удаагийн эргүүл шалгалтыг хийж хууль бус мод бэлтгэлийн 3 зөрчил илрүүлэн 1000 шахам иргэнд ой, хээрийн түймрийн сэрэмжлүүлэг гарын авлага материалыг тараалаа.

Түймрийн эрсдэлтэй хуурайшилттай үед ой, хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгалийн жамаар унасан бугын ясан эвэр түүхийг хязгаарлах, ой, хээрийг түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалтын ажлыг сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумын Цагдаагийн тасаг, хэсэг, Экологийн цагдаагийн алба хамтран зохион байгуулж байна.

### **Барилга, дэд бүтцийн чиглэлээр**

Барилгын материалын лаборатори элсний-2, хайрганы-1, үл эвдэх-1 шинжилгээг тус тус хийж гүйцэтгэн үр дүнг гаргасан.

2019 оны улсын төсвийн хөрөнгөөр “Хөх үзүүр” ХХК-ийн гүйцэтгэсэн Ирээдүй сургууль, цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажилд аймгийн Засаг даргын 2020 оны а/77 дугаар захирамжаар томилогдсон 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 3-р сарын 24-ний өдөр ажиллаж мэргэжилтнүүд хугацаатай үүрэг даалгавар өглөө.

36 иргэн, 4 төрийн байгууллага, 6 аж ахуйн нэгж, нийт 46 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших эрхийн гэрээ байгуулан шинээр гэрчилгээ олгосон байна.